



УВААГ

Óãñ àéí àëéí Àòãèòúí àãçàð

**ÓÃÑ ÀÉÌ ÆÈÉÌ ÕÀ ÑÃÈÉÌ
ТӨВЛӨРҮҮГЭ^а Í ÇÀÕÈÐÀÃ**

**2013 Î Í Û САНХҮҮГИЙН
Í ÝÃÒÃÝÑÝÍ ÕÀÉËÀÍ**

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:
Тэргүүлэх àóãèòí ð: Ë.Ãàò-Î ÷èð
Утас: 70453317

Аудитын менежер: С.Батжаргал
Утас: 70453721

Аудитор: Т.Намжил
Утас: 70453721

Àéì æéí аудитын газар

ÀçÃÒÃ-úí байр
Õèàái ãì ñóì
Óãñ àéì àã
Монгол Улс

Оршил
Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ
Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан
шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудитлагдсан санхүүгийн тайлан

2014 оны 04-р сарын 18

ÓÃÃÀГ-/2014/ -СТА

Оршил

Увс аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит дууссан тул энэхүү тайланг аймгийн Засаг даргад танилцуулж байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.4-д “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байхад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2014 оны 04 сарын 08-нд ирүүлэн хуулийн хугацааг ажлын 5 өдрөөр хэтрүүлсэн нь аудитын шалгалт хийх цаг хугацаанд сөргөөр нөлөөлж хүндрэл учруулсан болно.

Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа Улсын төсвийн байгууллагуудын хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон. Тухайн жилд асуудал үүсгэсэн тэдгээр хяналтыг бид аймгийн Засаг даргад тайлагнаж байна.

Бидний олж илрүүлсэн дараах асуудлын чиглэлд хяналтыг илүү сайжруулах шаардлагатай байна.

Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Төвлөрүүлэн захирагчдийн төсвийн нэгтгэсэн тайланд аймгийн Боловсрол 57, Эрүүл мэндийн 24, Соёлын 24, нийт 105 төсвийн байгууллагын тайлан хамрагдлаа.

I. Боловсролын салбарын байгууллагууд

II. Эрүүл мэндийн салбарын байгууллагууд

III. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын байгууллагууд

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг хураангуйлан гол асуудлуудыг дараах заалтад тэмдэглэв. Үүнд:

Нàí ò¿¿æéí òàéèàí æéí àóàèòààð í èèò 19 актаар 10.4 ñàÿ ò° æ° æéí àèò òí æí î æ 3884.8 ñàÿ ò° æ° æéí àèääàà ç° ð÷èè èèð¿¿èñí ýÿñ 3718.1 ñàÿ ò° æ° æéí àèääààãçàèðóóèèàà.

Боловсролын салбарын байгууллагууд:

Залруулсан алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залрууллаа.*

- Цогцолбор 2-р сургууль, Улаангом сумын Цогцолбор, 4, 9, Зүүнхангай, Сагил, Наранбулаг Өмнөговь, Давст, Бөхмөрөн, Малчин сумын Хүүхдийн цэцэрлэг, Малчин, Зүүнхангай, Тариалан, Наранбулаг, Өлгий, Тэс, Баруунтуруун, Бөхмөрөн сумдын Ахлах сургууль, Баруунтуруун сумын бага сургууль нийт 20 байгууллага 1883045.5 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан.
- Цогцолбор 1-р сургууль 2675.0 мянга, “Увс Эрдэм” ахлах сургууль 782.4 мянга, Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг 1390.0 мянга, нийт 4847.4 мянган төгрөгөөр зардлыг илүү тайлагнасан, Тэс, Баруунтуруун сумын Ахлах сургууль, Баруунтуруун сумын бага сургууль, Тэс, Давст, Цагаанхайрхан сумдын Хүүхдийн цэцэрлэг нийт 220683.5 мянган төгрөгөөр зардлыг дутуу илэрхийлсэн байна.
- Цогцолбор 1-р сургууль, Завхан, Бөхмөрөн, Улаангом сумын 5, 6, 9-р Хүүхдийн цэцэрлэг, Малчин, Зүүнхангай, Завхан, Бөхмөрөн сумдын Ахлах сургууль нийт 10 байгууллага 9890.1 мянган төгрөгийн зардлыг буруу ангилж тайлагнажээ.
- Цогцолбор 2-р сургууль, “Чандмань Эрдэм” ахлах сургууль, Улаангом сумын 4, 9-р цэцэрлэг, Зүүнхангай, Өмнөговь, Давст сумын Ахлах сургууль нийт 7 байгууллага 10013.5 мянган төгрөгийн авлага, Улаангом сумын Цогцолбор цэцэрлэг 137.0 мянга, Тэс сумын Ахлах сургууль 2900.0 мянга, нийт 3037.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Тариалан, Тэс, Баруунтуруун сумдын Ахлах сургууль, Тариалан сумын “Хархираа” бага сургууль, Тариалан, Тэс сумын Хүүхдийн цэцэрлэг нийт 6 байгууллага 265568.6 мянган төгрөгийн хөрөнгө, материалыг бүртгэлд тусгаагүй, буруу илэрхийлсэн.
- Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Давст сумдын Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг нийт 8 байгууллага төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 115251.6 мянган төгрөгийн орлогыг тусгажээ.
- Давст сумын Ахлах сургууль 18633.6 мянга, Хүүхдийн цэцэрлэг 129.3 мянга, нийт 18762.9 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн.
- Баруунтуруун сумын Хүүхдийн цэцэрлэг 451.5 мянга, Бөхмөрөн сумын Хүүхдийн цэцэрлэг 358.6 мянга, нийт 810.1 мянган төгрөгөөр дахин үнэлгээний зөрүүг буруу илэрхийлсэн.
- Тэс сумын Ахлах сургууль бэлэн мөнгөний кассын үлдэгдэл 2231.0 мянган төгрөгийг тайланд тусгаагүй байсныг тус тус санхүүгийн тайланд залрууллаа.

Залруулаагүй алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байна.*

- Цогцолбор 2-р сургууль, Ахлах 4-р сургууль, “Чандмань Эрдэм” ахлах сургууль, Улаангом сумын 3, 5, Малчин, Зүүнговь, Цагаанхайрхан, Бөхмөрөн, Хяргас сумын Хүүхдийн цэцэрлэг, Малчин, Завхан, Баруунтуруун, Давст, Цагаанхайрхан, Бөхмөрөн, Хяргас сумдын Ахлах сургууль нийт 17 байгууллага 44419.6 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

- Ахлах 4-р сургууль 472.1 мянга, 3-р цэцэрлэг 153.8 мянга, Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг 600.0 мянга, нийт 1225.9 мянган төгрөгийг бичдэж байна.
- Улаангом сумын 2-р цэцэрлэг 11600.0 мянга, Өндөрхангай сумын Хүүхдийн цэцэрлэг 64.9 мянга, Ховд сумын Ахлах сургууль 1300.0 мянга, нийт 12964.9 мянган төгрөгийн цалин, урамшууллыг олгохдоо хууль тогтоомжийг зөрчиж илүү олгосон байна.
- Улаангом сумын “Чандмань Эрдэм” ахлах сургууль, “Увс Эрдэм” ахлах сургууль, Өмнөговь, Цагаанхайрхан сумын Ахлах сургууль, Улаангом сумын 4, Малчин, Өмнөговь сумын Хүүхдийн цэцэрлэг нийт 7 байгууллага 2535.9 мянган төгрөгийн татвар шимтгэл дутуу суутгасан байна.
- Цогцолбор 2-р сургууль, “Увс Эрдэм” ахлах сургууль, Зүүнговь сумын ахлах сургууль, Улаангом сумын 4, 5, 8, 9, Зүүнговь, Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нийт 9 байгууллагын захирал, эрхлэгчид 3292.3 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл илүү олгожээ.
- Цогцолбор 2-р сургууль, Ахлах 3-р сургууль, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Зүүнговь сумын Ахлах сургууль, Зүүнговь сумын Хүүхдийн цэцэрлэг нийт 7 байгууллагын захирал, эрхлэгч өөртөө тушаал гарган үр дүнгийн урамшуулал цалин 9834.1 мянган төгрөг авсан байна.
- Цогцолбор 1-р сургууль 16683.6 мянга, “Увс Эрдэм” ахлах сургууль 5571.7 мянга, Давст сумын Ахлах сургууль 6156.0 мянга, нийт 28411.3 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн хяналтгүйгээр шууд зарцуулсан байна.
- Бөхмөрөн сумын Ахлах сургууль 815.0 мянган төгрөгийн малын тооцоо хийгээгүй байна.

Эрүүл мэндийн салбарын байгуулагууд

Залруулсан алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залрууллаа.*

- Малчин, Тариалан, Сагил, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Бөхмөрөн сумдын Эрүүл мэндийн төв нийт 200277.8 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан.
- Давст сумын Эрүүл мэндийн төв 7952.9 мянга Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв 30.5 мянга, Хяргас сумын Эрүүл мэндийн төв 11876.4 мянга, нийт 19859.8 мянган төгрөгөөр зардлыг илүү тайлагнасан, Улаангом сумын өрхийн эмнэлэг, Багийн эрүүл мэндийн төв, Тариалан, Тэс, Цагаанхайрхан сумдын Эрүүл мэндийн төв нийт 10710.4 мянган төгрөгөөр зардлыг дутуу илэрхийлсэн.
- Зүүнхангай, Зүүнговь, Цагаанхайрхан, Бөхмөрөн сумдын Эрүүл мэндийн төв нийт 2859.5 мянган төгрөгийн зардлыг буруу ангилж тайлагнажээ.
- Малчин сумын Эрүүл мэндийн төв 9286.0 мянган төгрөгийн эмийн эргэлтийн сангийн үлдэгдлийг, Тэс сумын Эрүүл мэндийн төв 26700.0 мянга, нийт 35986.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, данс бүртгэлд буруу илэрхийлсэн байна.
- Наранбулаг сумын Эрүүл мэндийн төв 9400.0 мянга, Өлгий сумын Эрүүл мэндийн төв 2600.0 мянга, Өмнөговь сумын Эрүүл мэндийн төв 51800.0 мянга, нийт 63800.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогоор тусгасан.

- Давст сумын Эрүүл мэндийн төв 4432.9 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг дутуу илэрхийлснийг тус тус санхүүгийн тайланд залрууллаа.

Залруулаагүй алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байна.*

- Малчин, Зүүнхангай, Сагил, Ховд, Түргэн, Өлгий, Өмнөговь, Зүүнговь, Давст, Хяргас, Бөхмөрөн сумдын Эрүүл мэндийн төв нийт 41108.7 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Хяргас сумын Эрүүл мэндийн төв 587.8 мянган төгрөгийн цалин, урамшуулал илүү олгожээ.
- “Дун цагаан” өрхийн эмнэлэг 10.4 мянга, “Мөнхбишрэлт” өрхийн эмнэлэг 50.4 мянга, Завхан сумын эрүүл мэндийн төв 172.3 мянга, нийт 233.1 мянган төгрөгийн татвар шимтгэл дутуу суутгасан байна.

Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын байгууллагууд

Залруулсан алдаа: *Дараах зөрчлүүдийг санхүүгийн тайланд залрууллаа.*

- Ойрад хөгжимт жүжгийн театр, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Малчин, Зүүнхангай, Завхан, Тариалан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Баруунтуруун, Бөхмөрөн сумдын Соёлын төв нийт 11 байгууллага 733021.1 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу тайлагнажээ.
- Номын сан 56.3 мянга, Тэс сумын Соёлын төв 356.0 мянга, нийт 412.3 мянган төгрөгөөр зардлыг илүү тайлагнасан, Ойрад хөгжимт жүжгийн театр 60.0 мянга, Номын сан 56.3 мянга, Тэс сумын Соёлын төв 218.0 мянга, нийт 334.3 мянган төгрөгөөр зардлыг дутуу илэрхийлсэн байна.
- Музей, Завхан, Тариалан, Баруунтуруун, Улаангом сумдын Соёлын төв нийт 50852.0 мянган төгрөгийн хөрөнгө, материал бүртгэлд тусгаагүй, данс бүртгэлд буруу илэрхийлсэн.
- Ойрад хөгжимт жүжгийн театр 29440.0 мянга, Тэс сумын Соёлын төв 6035.0 мянга, нийт 35475.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогоор тусгасан.
- Давст сумын Соёлын төв 2655.8 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн.
- Баруунтуруун сумын Соёлын төв 22805.6 мянга, Бөхмөрөн сумын Соёлын төв 712.7 мянга, нийт 23518.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг буруу илэрхийлсэн.
- Ойрад хөгжимт жүжгийн театр тендерийн бичиг баримтын үнэ 60.0 мянган төгрөгөөр орлогыг илүү илэрхийлснийг тус тус санхүүгийн тайланд залрууллаа.

Залруулаагүй алдаа:

- Ойрад хөгжимт жүжгийн театр, Малчин, Өндөрхангай, Түргэн, Бөхмөрөн, Хяргас сумдын Соёлын төв нийт 16191.9 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Ховд сумын Соёлын төв 74.7 мянган төгрөгийн зардал буруу ангилж тайлагнасан.

